**МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ**

2017 оны 11 сарын 29 өдөр                Дугаар А/210                Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалт, "Үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоолын 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр /2017-2020/-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралтаар батлсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/, Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Б.Алимаа/ нарт даалгасугай.

САЙД                С.ЧИНЗОРИГ

08    573

Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын
2017 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн
А/270 тоот тушаалын хавсралт

# ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮНДЭСНИЙ ТАВ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2017-2020 он/

| Зорилго | | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хөтөлбөрийн зорилго нь ХАБЭА-н хууль эрх зүй, стандартын зохицуулалтыг боловсронгуй болгох, хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсч байгаа хүчин зүйл, шалтгааныг тогтоож, үйлдвэрлэлийн осол, ослын тохиолдлыг бууруулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх, ажиллагчдын эрүүл мэндийг хамгаалах тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэгдэнэ. | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **№** | **Үйл ажиллагаа** | **Бүтээгдэхүүн** | **Шалгуур үзүүлэлт** | **Хэрэгжилтийг хариуцах байгууллага** | **Хамтран хэрэгжүүлэх байгууллага** | **Хэрэгжих хугацаа /он/** |
| **Зорилт 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүй, стандартын зохицуулалтыг үндэсний онцлогт нийцүүлэн олон улсын хэм хэмжээ, нийтлэг зарчим, жишиг түвшинд хүргэн боловсронгуй болгоно.** | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 1.1** Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулж,үйлдвэрлэлийн осол гаргаагүй ажил олгогчийг урамшуулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх, эмчлэх, сувилах, ХАБЭА-н урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох | | | | | | |
| 1.1.1 | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах санал боловсруулж, шийдвэрлүүлэх | Хууль - 1 | Хуульд нэмэлт өөрчлөлт орсон байна. | ХНХЯ | ЭМНДЕГ, ХАБЭМТ | 2017-2019 |
| 1.1.2 | ХАБЭА-н тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох дүрэм, журмыг шинэчлэх<br>- ХАБЭА-н сургалт зохион байгуулах, шалгалт авах журам"<br>- "Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага" шалгаруулах журам<br>- "Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тариф"<br>- "Химийн хорт бодистой харьцан ажиллах ажилтанд олгох эмчлэн сэргийлэх хоол, хүнсний бүтээгдэхүүний зөвлөмж"<br>- "Ажлын тусгай хувцас хамгаалах | Дүрэм, журам - 6 | Дүрэм, журам шинэчлэгдсэн байна. | ХНХЯ, ХАБЭМТ | МХЕГ, НЭМҮТ, АШУҮИС | 2017-2019 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгслийн үлгэрчилсэн жагсаалт"<br>- Асбест агуулсан бүтээгдэхүүнтэй харьцах аюулгүй ажиллагааны журам | | | | | |
| 1.1.3 | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбогдуулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалаар батлагдсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт"-ыг шинэчлэн боловсруулах | Жагсаалт - 1 | Жагсаалт шинэчлэн боловсруулагдсан байна. | ХНХЯ | ХАБЭМТ, ЭМНДЕГ | 2018 |
| **Үйл ажиллагааны чиглэл 1.2** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартуудыг олон улсын жишиг, үндэсний онцлогт нийцүүлэн шинэчлэх, салбарын түвшинд мөрдөгдөж байгаа ХАБЭА-н стандарт, норм, дүрэм, журмыг шинэчлэн боловсруулах, хэрэгжүүлэхэд салбарын яамдын оролцоог нэмэгдүүлэх | | | | | | |
| 1.2.1 | ХАБЭА-н стандартын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөг үнэлж судалгаа хийж, шинэчлэх стандартын жагсаалт гаргаж, жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх | Судалгааны тайлан, стандарт - 1 | Стандартуудыг судалж, шинэчлэн боловсруулж батлуулсан байна. | ХНХЯ | СХЗГ, МХЕГ, АШУҮИС | 2017-2020 |
| 1.2.2 | Салбарын түвшинд мөрдөгдөж буй ХАБЭА-н стандарт, норм, дүрэм, журамд нөхцөл байдлын үнэлгээг салбар тус бүрээр хийж дүгнэлт гарган, шинээр батлах, шинэчлэн боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах | Салбар тус бүрийн шинэчлэгдсэн стандарт, норм, дүрэм | ХАБЭА-н стандарт, норм, дүрэм, журам, стандарт шинэчлэгдсэн байна. | Яамд | ХНХЯ, ХАБЭА-н салбар хороо | 2017-2020 |
| 1.2.3 | Уул уурхайн салбар дахь эрсдэл ихтэй ажлын байрны ХАБЭА-н жишиг зааварчилгаа боловсруулж хэвлүүлэх | Жишиг зааварчилгаа - 1 | Зааварчилгаа боловсруулж хэвлүүлсэн байна. | УУХҮЯ, ХНХЯ | ГОУХАН-ЭТИС хөтөлбөр | 2017 |
| 1.2.4 | Барилгын салбар дахь эрсдэл ихтэй ажлын байрны ХАБЭА-н жишиг зааварчилгаа боловсруулж хэвлүүлэх | Жишиг зааварчилгаа - 1 | Зааварчилгаа боловсруулж хэвлүүлсэн байна. | БХБЯ, Барилгачдын холбоо | ХНХЯ | 2018 |
| 1.2.5 | Цахилгаан соронзон орчинд ажилладаг ажилтны хамгаалалт, аюулгүй байдал, эрүүл ахуйн гарын авлага, заавар, зөвлөмж боловсруулах | Гарын авлага - 1 | Сургалт сурталчилгааны гарын авлагаар хангагдсан байна. | ЭХЯ | ХАБЭА-н салбар хороо | 2017-2019 |
| **Үйл ажиллагааны чиглэл 1.3** ХАБЭА-н үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр салбарын яамд, аймаг, нийслэл, дүүрэгт ХАБЭА-н дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | | | | | | |
| 1.3.1 | Салбарын яамд, аймаг, нийслэл, дүүрэгт ХАБЭА-н дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх | Дэд хөтөлбөр - 35 | Дэд хөтөлбөр батлагдаж, хэрэгжсэн байна. | Яамд, Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, ХАБЭА-н зөвлөл | ХНХЯ, ХАБЭА-н Үндэсний хороо | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл 1.4** Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаарх Олон улсын хөдөлмөрийн зарим конвенцид нэгдэх асуудлыг судлан шийдвэрлэх | | | | | | |
| 1.4.1 | Хөдөлмөрийн хяналтын тухай ОУХ-ын 81 дүгээр конвенцид нэгдэн орох | Конвенци - 1 | Конвенцид нэгдэн орсон байна. | МХЕГ | ХНХЯ, МҮЭХ, МАОЭНХ | 2017-2018 |
| 1.4.2 | Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай ОУХ-ын 129 дүгээр конвенцид нэгдэн орох | Конвенци - 1 | Конвенцид нэгдэн орсон байна. | МХЕГ, ХХААХҮЯ | ХНХЯ, МҮЭХ, МАОЭНХ | 2017-2018 |
| 1.4.3 | Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээний тухай ОУХ-ын 161 дугаар конвенцийг судалж, санал боловсруулах | Конвенци - 1 | Конвенцийг судалж, санал боловсруулсан байна. | ХАБЭМТ, ХНХСИ | МХЕГ, АШУҮИС | 2018-2020 |
| 1.4.4 | Барилгын салбар дахь ХАБЭА-н тухай ОУХ-ын 167 дугаар конвенцид нэгдэн орох | Конвенци - 1 | Конвенцид нэгдэн орсон байна. | БХБЯ | ХНХЯ, МХЕГ, МҮЭХ, МАОЭНХ | 2017-2018 |
| **Үйл ажиллагааны чиглэл 1.5** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэд хийх үзлэгийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналт, орон нутгийн холбогдох байгууллага болон түншлэгч талуудын оролцоотойгоор зохион байгуулах | | | | | | |
| 1.5.1 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэг зохион байгуулах | Улсын үзлэг - 1 | Улсын үзлэг хийгдэж, дүнг нэгтгэсэн байна. | ХНХЯ, ХХААХҮЯ, МХЕГ, ХАБЭМТ | Аймаг, нийслэл, дүүргийн ХХҮГ, орон нутгийн ХАБЭА-н зөвлөл | 2018-2019 |
| 1.5.2 | Орон нутагт ХАБЭА-н тухай хуулийн хэрэгжилтийн үзлэгийг дэд хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх | Үзлэг - 1 | Үзлэг хийгдэж, дүнг нэгтгэсэн байна. | Аймаг, нийслэл, дүүргийн ХХҮГ, орон нутгийн ХАБЭА-н зөвлөл | Аймаг, нийслэл, дүүргийн НДХ, МХГ, ЭМН | 2018 |
| 1.5.3 | Жил бүр Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран ажиллах төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх | Төлөвлөгөө - 3 | Төлөвлөгөө хэрэгжсэн байна. | ХНХЯ, МХЕГ | ХАБЭА-н Үндэсний хороо, ХАБЭМТ | 2018-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 1.6** Бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах | | | | | | |
| 1.6.1 | Бичил уурхай эрхлэгчдийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Журам - 1 | Журам батлагдсан байна. | УУХҮЯ, АМГТГ | ХНХЯ, Салбар хороо | 2017 |
| 1.6.2 | Бичил уурхай эрхлэгчдийн судалгааг жил бүр авч, нэгтгэн дүгнэх | Судалгаа – 3 | Судалгаа хийгдсэн байна. | ХНХЯ, Бичил уурхайн ХАБЭА-н дэд хороо | ШХА, Аймаг, нийслэл, дүүргийн ХХҮГ | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.6.3 | Бичил уурхай эрхлэгч болон тэдний гэр бүлийнхнийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд сургалтанд хамруулж, сурталчилгааг тогтмолжуулах | Сургалтын хөтөлбөр, сурталчилгааны материал - 1 | Бичил уурхайчид болон тэдний гэр бүлийн гишүүд хамрагдсан байна. | ХАБЭМТ | ХНХЯ | 2018-2020 |
| 1.6.4 | Бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн даатгалд бичил уурхайчдын хамруулах нэгдсэн бүртгэлтэй болгох | Бүртгэл - 1 | Бичил уурхай эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулж, бүртгэлжүүлсэн байна. | ЭМНДЕГ | ХНХЯ | 2017-2020 |
| **Зорилт 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх арга хэмжээг үндэсний болон орон нутаг, салбарын түвшинд, аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байранд шинэлэг, үр нөлөөтэй арга хэлбэрээр тогтмол зохион байгуулж, хууль тогтоомж, стандартыг мөрдүүлж хэвшүүлнэ.** | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.1** Хүүхэд, өсвөр насныханд эрүүл, аюулгүй ажиллаж амьдрах арга барил, зан үйл, соёлыг ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн агуулгаар эзэмшүүлэх, ХАБЭА-н сургалтын байгууллага, хүүхдийн төлөө ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог дэмжих | | | | | | |
| 2.1.1 | Ерөнхий боловсролын сургуулийн /5-12 анги/ сургалтын хөтөлбөрт ХАБЭА-н анхан шатны мэдлэг, соёл, хандлагыг төлөвшүүлэх асуудлыг тусгах | Сургалтын хөтөлбөр - 1 | Сургалтын хөтөлбөрт ХАБЭА-н асуудал тусгагдсан байна. | БСШУСЯ | ХАБЭМТ | 2018 |
| 2.1.2 | Хүүхэд, өсвөр насныханд эрүүл, аюулгүй ажиллах, амьдрах арга барил, зан үйлийг төлөвшүүлэхэд ХАБЭА-н сургалтын байгууллага болон хүүхдийн төлөө ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог өргөжүүлэх | Сургалт – 4 | Сургалтын байгууллагууд зорилтот бүлэг рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулж тогтмолжсон байна. | ГБХЗГ<br>Сургалтын байгууллагууд | ХАБЭМТ | 2018-2020 |
| 2.1.3 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ХАБЭА-н сургалтын хөтөлбөр /модуль/ боловсруулж хэрэгжүүлэх | Сургалтын хөтөлбөр - 1 | Сургалт хөтөлбөр боловсруулагдсан байна. | ХАБЭМТ, ТББ | ХНХЯ | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.2** ХАБЭА-н бакалавр, магистрын түвшний болон зайны, цахим сургалтын хөтөлбөрийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх | | | | | | |
| 2.2.1 | ХАБЭА-н бакалавр, магистрын түвшний болон зайны, цахим сургалтын хөтөлбөрийг боловсруулах | Сургалтын хөтөлбөр - 3 | Хөтөлбөр боловсруулсан байна. | АШУҮИС, МАОЭНХ, ХАБЭМТ, Сургалтын байгууллага | ХНХЯ | 2017-2018 |
| 2.2.2 | Их, дээд сургууль, коллежи, МСҮТ-ийн сургалтын агуулгад ХАБЭА-н хичээлийг оруулж, багш нарыг мэргэшүүлэх, гарын авлага, материал бэлтгэх | Сургалтын хөтөлбөр, гарын авлага, материал - 4 | Сургалтын агуулгад ХАБЭА-н хичээл орж, багш нар мэргэшиж, гарын авлага, сурах бичигтэй болсон байна. | БСШУСЯ, АШУҮИС, "Оюу толгой" ХХК, "ОШМИ" ХХК, МАОЭНХ | ХНХЯ, ХАБЭА-н Үндэсний хороо | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.2.3 | ХАБЭА-н ажилтныг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох | Сургалтын хөтөлбөр - 1 | Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр боловсронгуй болсон байна. | ХНХЯ | ХАБЭМТ, МАОЭНХ | 2018 |
| 2.2.4 | ХАБЭА-н ажилтны мэргэшлийн зэрэг олгох журам боловсруулах | Журам – 1 | Мэргэжлийн зэрэг олгох журам боловсруулагдсан байна. | ХНХЯ, ХАБЭА-н Үндэсний хороо | Холбогдох төрийн болон ТББ | 2017-2018 |
| 2.2.5 | Залуучуудад зориулсан ХАБЭА-н сургалт, үйл ажиллагааны модулийг боловсруулж хэрэгжүүлэх | Сургалтын хөтөлбөр - 1 /модуль/ | Сургалтын хөтөлбөр боловсруулагдсан байна. | ХНХЯ, ГБХЗГ | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, МАОЭНХ, МҮЭХ | 2017-2018 |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.3** Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жижиг, дунд үйлдвэрлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд хариуцан зохион байгуулах | | | | | | |
| 2.3.1 | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг дэд хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх | Сургалт - 30 | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж хэвшсэн байна. | Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, ХАБЭА-н зөвлөл | Аймаг, нийслэл, дүүргийн ИТХ | 2017-2020 |
| 2.3.2 | Жил бүр ҮОМШӨ-ний даатгалын сангаас ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н сургалт, сурталчилгаа зохион байгуулах арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө гаргаж, ТББ-аар ажил гүйцэтгүүлэх | Төлөвлөгөө - 4 | ХАБЭА-н урьдчилан сэргийлэх асуудлаар оролцогч талуудын үйл ажиллагаа тодорхой болгож хамтын ажиллагаа өргөжсөн байна. | ХАБЭА-н Үндэсний хороо, ЭМНДЕГ | ХАБЭМТ, МАОЭНХ, МҮЭХ, ТББ, Мэргэжлийн холбоод | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.4** Нийт иргэдэд эрүүл, аюулгүй ажиллаж амьдрах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зан үйлийг бий болгох, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахад хэвлэл мэдээллийн байгууллагыг оролцуулах боломж, нөхцөлөөр хангах | | | | | | |
| 2.4.1 | ХАБЭА-н сарын аяныг орон нутаг, салбарын түвшинд зохион байгуулах | Сарын аян - 4 | Жил бүр компанит ажил зохион байгуулсан байна. | ХАБЭМТ, МХЕГ, МҮЭХ, МАОЭНХ, Салбар хороо, аймаг, нийслэл дүүргийн ХАБЭА-н зөвлөл | ХНХЯ | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.4.2 | ХАБЭА-н урьдчилан сэргийлэх асуудлаар иргэдэд үндэсний болон хувийн ТВ-үүдээр мэдээлэл түгээдэг болох | Хөтөлбөр | Мэдээлэл гарч тогтмолжсон байна. | ХНХЯ, МҮЭХ, МАОЭНХ | МҮОНРТ, ХАБЭМТ | 2017-2020 |
| 2.4.3 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шторк, тараах материал, санал зөвлөмжийг хэвлүүлэх, өдөр тутмын сонин, хэвлэлээр урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгааг тогтмолжуулах | Сурталчилгааны материал | Сурталчилгааны материалыг олон нийтэд түгээж, олон нийтийг мэдээллээр хангасан байна. | Салбарын яамд Аймаг, нийслэл, дүүргийн ХАБЭА-н зөвлөл, ХАБЭМТ | Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, ИТХ, МҮЭХ, МАОЭНХ | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.5** Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийдэг лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлж, үнэлгээ хийх нөхцөл боломжоор хангах | | | | | | |
| 2.5.1 | Аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэргэдэх лабораторийн хүчин чадлыг сайжруулж, хэмжилт шинжилгээний үзүүлэлтийн тоог нэмэгдүүлэх боломжоор хангах | Тоног төхөөрөмж | Лабораторийн тоног төхөөрөмжийн хүчин чадал сайжирсан байна. | МХЕГ | Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар | 2017-2020 он |
| 2.5.2 | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийдэг лабораториудын сүлжээ бий болгож, хамтран ажиллах, лабораторийн зарим нарийвчилсан хэмжилт, шинжилгээг дагнан хийх нөхцөлийг бүрдүүлэх | Лабораторийн сүлжээ | Лабораторийн сүлжээ бий болж, хэмжилт шинжилгээ хийх нөхцөл сайжирсан байна. | ХАБЭМТ, МХЕГ | ХНХЯ | 2017-2020 |
| 2.5.3 | Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг баталгаажуулах сорилын лабораторийг бий болгох | Лаборатори | Сорилын лаборатори бий болсон байна. | МХЕГ, ХАБЭМТ | ХНХЯ, СХЗГ | 2017-2020 |
| 2.5.4 | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх хувийн итгэмжлэгдсэн лабораториудын чадавхийг сайжруулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах | Сургалт | Лабораториудын чадавхи сайжирч сургалт зохион байгуулагдсан байна. | ХАБЭМТ | ХНХЯ | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.6** Ажлын байран дахь асбесттай холбоотой өвчний оношлогоо, бүртгэл, тандалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах | | | | | | |
| 2.6.1 | Асбесттай холбоотой өвчнөөр өвдөх эрсдэлтэй ажилтнуудыг оношлох, бүртгэх, мэдээлэх тогтолцоог бий болгох | Бүртгэл | Асбесттай холбоотой өвчнөөр өвдөх эрсдэлтэй ажилтнуудын бүртгэлтэй болсон байна. | ХАБЭМТ | ХНХЯ, МХЕГ, АШУҮИС | 2017-2020 |
| 2.6.2 | Асбесттай холбоотой өвчнүүдийг МШӨ-ний жагсаалтад оруулах асуудлыг шийдвэрлэх | Жагсаалт | МШӨ-ний жагсаалтад орсон байна. | ХАБЭМТ | ХНХЯ, ЭМЯ, АШУҮИС | 2017-2019 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.6.3 | Асбест агуулсан бүтээгдэхүүнийг хязгаарлах, орлох бүтээгдэхүүний хэрэглээг дэмжих, сурталчилах | Сурталчилгаа | Мэдээлэл, сурталчилгаа сайжирсан байна. | ЭМЯ, БОАЖЯ, МХЕГ | ХАБЭМТ | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 2.7** Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, шинэ арга, технологийн туршилт, судалгаа, инновацийг дэмжих болон ХАБЭА-н асуудлаар эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарч ажиллах | | | | | | |
| 2.7.1 | Бодлого, шийдвэрийг тодорхойлоход хэрэгцээтэй ХАБЭА-н суурь судалгаануудыг Шинжлэх ухаан технологийн сантай хамтран хэрэгжүүлж ашиглах | Судалгаа | Судалгааг бодлого шийдвэрт тусгаж эхэлсэн байна. | ХНХЯ, Шинжлэх ухаан технологийн сан | НЭМҮТ, ХАБЭМТ, АШУҮИС-ийн НЭМС, ШУТҮИС, | Тухай бүр |
| 2.7.2 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, шинэ арга, технологийн туршилт, судалгаа, инновацийг дэмжих асуудлаар ОУ-ын байгууллагуудтай хамтарч ажиллах | Шинэ арга, туршлага | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, шинэ арга, технологи нэвтрүүлсэн байна. | ХАБЭМТ, ХНХСИ, МХЕГ, АШУҮИС, ШУТИС | ХНХЯ | 2017-2020 |
| 2.7.3 | ХАБЭА-н чиглэлээр их, дээд болон политехникийн коллежи, МСҮТ-ийн оюутан, залуучуудын дунд шилдэг илтгэл бичих уралдаан зарлан дүгнэж байх | Уралдаан - 3 | Уралдаан зарлагдан дүгнэгдэж, шилдэг бүтээлийг нийтэд сурталчилж, түгээсэн байна. | ХНХЯ | ХАБЭМТ, АШУҮИС-ийн НЭМС, ШУТҮИС | Жил бүр |
| **Зорилт 3. ХАБЭА-н хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахад ажил олгогчийн үүрэг хариуцлагыг дээшлүүлж, ажилтнууд аюул эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах зөв хандлагыг төлөвшүүлнэ.** | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.1** Аж ахуйн нэгж, байгууллагууд "Ослыг тэглэх, осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө" боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж хэвших | | | | | | |
| 3.1.1 | ААНБ жил бүр ХАБЭА-н төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах | Төлөвлөгөө | Жил бүр төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж хэвшсэн байна. | ААНБ-ууд | МХЕГ, МҮЭХ, МАОЭНХ, ХАБЭА-н зөвлөл | Жил бүр |
| 3.1.2 | ААНБ жил бүр шинээр ажилд орсон болон залуу ажилтнуудад зориулсан аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх сургалтыг байгууллагын төлөвлөгөөнд тусган тогтмол зохион байгуулж хэвших | Сургалт | Зорилтот бүлэг рүү чиглэсэн сургалтыг зохион байгуулж хэвшсэн байна. | ААНБ-ууд | МАОЭНХ, МҮЭХ, МХЕГ, ХХҮГ | Жил бүр |
| 3.1.3 | ААНБ бүр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ХАБЭА-н асуудлаар дүрэм, журам боловсруулж, мөрдөж хэвших | Дүрэм, журам | Урьдчилан сэргийлэх асуудлаар тогтмол мөрддөг арга хэмжээтэй болсон байна. | ААНБ-ууд | ХАБЭА-н Үндэсний хороо, МХЕГ, МАОЭНХ | 2017-2020 |
| 3.1.4 | ААНБ жил бүр ажилтнуудаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж, үзлэгийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч, эрүүл мэндэд нь анхаардаг хэвшлийг бий болгох | Эрүүл мэндийн үзлэг | ААНБ жил бүр ажилтнуудаа эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг хэвшил бий болсон байна. | ААНБ-ууд | ЭМЯ, МХЕГ, ХАБЭМТ, МҮЭХ, МАОЭНХ, ХАБЭА-н зөвлөл | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл 3.2** Ажлын байр, үйлдвэрлэлийн орчинд гарч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, дохио, санамж, анхааруулга, тэмдэг тэмдэглэгээ тавьж, хаалт хамгаалалтыг бүрэн хийж хэвшихэд ажил олгогч бүр санаачилгатай хандаж, аюулгүй орчныг бүрдүүлэх | | | | | | |
| 3.2.1 | Ажлын байран дахь урьдчилсан, анхан шатны, давтан зааварчилгаар стандарт шаардлагын дагуу ажилтанд тогтмол өгч хэвшүүлэх | Зааварчилгаа | Хэвшсэн байна. | ААНБ-ууд | Ажил олгогч, ХАБЭА-н зөвлөл | 2017-2020 |
| 3.2.2 | Аюул, ослоос урьдчилан сэргийлэх үүднээс дохио, санамж, анхааруулга, тэмдэг, тэмдэглэгээ, хаалт, хамгаалалтыг ААНБ бүр хэрэглэж хэвших | Хаалт, хамгаалалт, тэмдэглэгээ | Анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэж хэвшсэн байна. | ААНБ-ууд | Ажил олгогч, ХАБЭА-н зөвлөл | 2017-2020 |
| 3.2.3 | Аж ахуйн нэгж байгууллага бүр тодорхой хугацаанд ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийж хэвших | Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ | Үнэлгээ хийгдэж, аюул ослыг арилгасан байна. | ААНБ-ууд | Ажил олгогч, ХАБЭА-н зөвлөл | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.3** Аж ахуйн нэгж, байгууллага бүр ажилтнуудыг шаардлага хангасан ахуйн байраар хангах, алжаал /стресс сэтгэлийн хямрал/ тайлах, чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөн хийх өрөө танхимтай болох хөдөлгөөн өрнүүлэх | | | | | | |
| 3.3.1 | Ажилтны стресс тайлах, чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөн хийх өрөө танхимтай болох хөдөлгөөнийг өрнүүлж ажиллах | Өрөө, танхим | Чийрэгжүүлэх өрөө, танхимтай болсон байна. | ААНБ-ууд | ХАБЭМТ, МХЕГ, МҮЭХ, МАОЭНХ | 2017-2020 |
| 3.3.2 | Ажилтныг түр амарч дулаацах, сэрүүцэх, хооллох, усанд орох, эрүүл ахуйн шаардлага хангасан ахуйн байраар бүрэн хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Ахуйн байр | Ахуйн байраар хангагдсан байна. | ААНБ-ууд | ХАБЭМТ, МХЕГ, МҮЭХ, МАОЭНХ | 2017-2020 |
| 3.3.3 | Томоохон аж ахуйн нэгж байгууллагуудад орон тооны сэтгэл зүйч авч ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх | Орон тооны ажилтан | Аж ахуйн нэгж байгууллага сэтгэл зүйчтэй болсон байна. | ААНБ-ууд | МАОЭНХ, МҮЭХ, ААНБ | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.4** Аж ахуйн нэгж, байгууллага ХАБЭА-н алба, ажилтны орон тоо, бүтцээр ажиллуулах, байгууллагын ХАБЭА-н зөвлөл, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг байгуулж, гишүүдийг дадлагажуулах, чадавхижуулах ажлыг зохион байгуулах | | | | | | |
| 3.4.1 | "Аж ахуйн нэгж байгууллагын ХАБЭА-н зөвлөл, орон тооны ажилтан ажиллуулах норматив"-ыг мөрдөж ажиллах | Бүтэц, орон тоо | ХАБЭА-н бүтэц, нэгж ажиллуулж хэвшсэн байна. | МАОЭНХ, ААНБ-ууд | МХЕГ, Аймаг, нийслэл, дүүргийн ХАБЭА-н зөвлөл | 2017 оноос |
| 3.4.2 | "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийн заалтыг хэрэгжүүлж ажиллах | Комисс | Гишүүд чадавхижиж, комиссын үйл ажиллагаа жигдэрсэн байна. | ААНБ-ууд | МХЕГ, МАОЭНХ | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.5** Ажил олгогч ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах, сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах зэрэг асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжүүлж байх | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.5.1 | Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг итгэмжлэл авсан байгууллагаар хийлгэж, дүгнэлт гаргах зөвлөмж боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах | Зөвлөмж | Арга зүйн зөвлөмж боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | ХАБЭМТ, Итгэмжлэгдсэн лабораториуд | МХЕГ, МАОЭНХ, МҮЭХ | 2017-2020 |
| 3.5.2 | ХАБЭА-н тухай хуульд заасан ажлын тусгай хувцасаар хангах, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, ажлын байрыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх зэрэг асуудлыг хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд тусгаж хэрэгжүүлэх | Хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ | ХАБЭА-н асуудал хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан байна. | ААНБ-ууд | МХЕГ, МАОЭНХ, МҮЭХ | 2017-2020 |
| 3.5.3 | Мэргэжлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох зэрэг асуудлыг хамтын гэрээнд тусгаж хэрэгжүүлэх | Хамтын гэрээ | Мэргэжлийн зэрэг, хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдлийг хамтын гэрээнд тусгасан байна. | ААНБ-ууд | МХЕГ, МАОЭНХ, МҮЭХ | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 3.6** ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээг ажилтан бүрт ойлгомжтой, энгийн, хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулах, ХАБЭА-н шилдэг арга барил, туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлэх, бусдаас харилцан суралцах ажлыг зохион байгуулах | | | | | | |
| 3.6.1 | "Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага" шалгаруулах арга хэмжээг жил бүр зохион байгуулж, шалгарсан байгууллагын туршлагыг олон нийтэд түгээх | Болзолт уралдаан - 4 | Болзолт уралдааныг зарлаж, шалгарсан ААНБ-д шагнал гардуулсан байна. | ХАБЭА-н Үндэсний хороо, ХАБЭМТ | ХАБЭМТ, Аймаг, нийслэл, дүүргийн ХАБЭА-н зөвлөл | Жил бүр |
| 3.6.2 | ХАБЭА-н сайн туршлагыг түгээх чиглэлээр жил бүр эмхэтгэл хэвлүүлэх | Эмхэтгэл | Эмхэтгэл гаргасан байна. | ХНХЯ | ХАБЭМТ, ААНБ | Жил бүр |
| 3.6.3 | ХАБЭА-н үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сурталчлах асуудлыг зохион байгуулах | Хөтөлбөр | Үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөрийг сурталчилсан байна. | ХАБЭА-н Үндэсний хороо, ХАБЭМТ | Аймаг, нийслэл, дүүргийн ХАБЭА-н зөвлөл | 2017 |
| **Зорилт 4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, хяналтанд авах үйл ажиллагааг сайжруулж, ажилтнуудын хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх, сувилах замаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бууруулна.** | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 4.1** Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эмчлэх, сувилах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх замаар ажилтнуудад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх | | | | | | |
| 4.1.1 | Аймаг, нийслэл, дүүрэг, сумын эмнэлгүүдэд мэргэжлээс шалтгаалсан өвчний анхан шатны үзлэг хийдэг нөхцөлийг бүрдүүлэх | Үзлэг | Анхан шатны үзлэгийг хийдэг болсон байна. | ЭМЯ, ХАБЭМТ | Аймаг, нийслэл, дүүрэг, сумын ЭМН | 2017-2020 он |
| 4.1.2 | Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эмчлэх, сувилах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллагуудын | Сургалт, семинар | Хувийн хэвшлийн байгууллагуудын МШӨ-нийг оношлох, эмчлэх, | ХАБЭМТ | ЭМНДЕГ | 2018 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааг дэмжиж мэргэжил арга зүйгээр хангах | | сувилах үйл ажиллагаа идэвхжсэн байна. | | | |
| 4.1.3 | Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн төв болон үйлдвэр уурхайн эмч нарт мэргэжлээс шалтгаалсан өвчний талаарх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах | Сургалт | Эрүүл мэндийн төв болон үйлдвэр уурхайн эмч нар МШӨ-ний талаар мэдлэг эзэмшсэн байна. | ХАБЭМТ | ЭМЯ, ЭМНДЕГ | 2018 |
| **Үйл ажиллагааны чиглэл 4.2** Мэргэжлээс шалтгаалсан өвчний оношлогоо, эмчилгээнд шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, үзлэг, оношлогоо, эмчилгээний чанарыг сайжруулах | | | | | | |
| 4.2.1 | Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эмчлэх, сувилах, нөхөн сэргээх үйлчилгээг сайжруулж, хэвтэн эмчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх | Үйлчилгээ | Эмчлэх, сувилах, нөхөн сэргээх үйлчилгээ сайжирч, хэвтэн эмчлэх нөхцөл бүрдсэн байна. | ХАБЭМТ | ХНХЯ, ЭМНДЕГ | 2017-2020 он |
| 4.2.2 | Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын клиник лабораторийн багаж, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулан шинжилгээний тоо төрлийг нэмэгдүүлэн улсын хэмжээний итгэмжлэгдсэн лабораторитой болох | Лаборатори | Лабораторитой болсон байна. | ХАБЭМТ | ЭМНДЕГ | 2017-2020 |
| 4.2.3 | Зонхилон тохиолдох мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, шинжлэх тоног төхөөрөмжийн хүрэлцээг нэмэгдүүлэх | Багаж, тоног төхөөрөмж | Тоног төхөөрөмжтэй болсон байна. | ХАБЭМТ | ЭМНДЕГ | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 4.3** Хөдөлмөрийн эрүүл ахуйч, мэргэжлээс шалтгаалсан өвчний эмч, сувилагч, мэргэжилтнүүдийг урт, богино хугацааны сургалтанд хамруулах, мэргэшүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах арга хэмжээг авах | | | | | | |
| 4.3.1 | Туяаны болон хордлогын зэрэг нарийн эмч нарыг бэлтгэх | Сургалт | Эмч нар мэргэшсэн байна. | ЭМЯ, ХАБЭМТ | АШУҮИС | 2018-2020 |
| 4.3.2 | Мэргэжлээс шалтгаалсан өвчний чиглэлээр ажиллаж байгаа эмч,сувилагч,хөдөлмөрийн эрүүл ахуйч, мэргэжилтнүүдийг мэргэжлийн чиглэлээр сургалтанд хамруулах | Сургалт | Сургалтанд хамрагдсан байна. | ЭМЯ, ХНХЯ | ХАБЭМТ | 2017-2020 |
| 4.3.3 | Мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, магадлах чадавхийг сайжруулах арга хэмжээ авах | Сургалт | Мэргэжилтнүүд чадавхижсан байна. | ХАБЭМТ,ЭМЯ, АШУҮИС | ХНХЯ | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 4.4** Хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан ажилтнуудын хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх төв, кабинетыг орон нутгийн түвшинд ажиллуулах арга хэмжээг зохион байгуулж, эрүүл мэндийн нөхөн сэргээх сувиллуудын хүртээмж, үйлчилгээний чанарыг сайжруулж, үйл ажиллагааг тогтмолжуулах | | | | | | |
| 4.4.1 | Мэргэжлээс шалтгаалсан өвчний нөхөн сэргээх сувиллын багаж төхөөрөмжийг сайжруулах, хөдөлмөрийн чадвар алдсан иргэдэд зориулсан үйлчилгээг бий болгох | Сувилал | Нөхөн сэргээх сувиллын үйлчилгээ сайжирсан байна. | ХАБЭМТ | ЭМНДЕГ | 2017-2020 |
| 4.4.2 | ХАБЭМТ-ийн харьяа “Агаар” сувиллын үйл ажиллагааг тогтмолжуулах | Сувилал | Сувилал үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. | ХАБЭМТ | ЭМНДЕГ | 2017-2019 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.4.3 | МШӨ-ний сувиллуудын үйл ажиллагааг идэвхжүүлж, эмч,сувилагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах | Сургалт | Сувиллуудын үйл ажиллагаа идэвхжин нөхөн сэргээх үйлчилгээг чанартай үзүүлж, эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулсан байна. | ХАБЭМТ | ЭМНДЕГ | 2017-2020 |
| 4.4.4 | Аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвүүд, үйлдвэр аж ахуйн газруудад МШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан иргэдэд зориулсан нөхөн сэргээх кабинет ажиллуулах | Кабинет | Аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвүүд, үйлдвэр аж ахуйн газруудад нөхөн сэргээх, физик эмчилгээний кабинет ажиллуулсан байна. | ЭМЯ | ХАБЭМТ | 2018 |
| **Үйл ажиллагааны чиглэл 4.5** Нийгмийн даатгал, эрүүл мэндийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтнуудын бие бялдрыг нөхөн сэргээх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсч байгаа хүчин зүйл, шалтгааныг тогтоож, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх | | | | | | |
| 4.5.1 | МШӨ-ний хяналтанд байгаа өвчтөнүүдийг үнэ төлбөргүй үзлэг оношлогоонд хамрагддаг тогтолцоог боловсронгуй болгох, эрүүл мэндийн даатгалын системд хамруулах | Үзлэг | Хяналтанд байгаа өвчтөнүүд эрүүл мэндийн даатгалаар үнэ төлбөргүй үзүүлдэг болно. | ХАБЭМТ | ЭМНДЕГ | 2017-2020 |
| 4.5.2 | МШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийг дахин мэргэшүүлэх сургалтанд хамруулах | Сургалт | Хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтнууд сургалтанд хамрагдаж, ажлаар хангагдах нөхцөл бүрдсэн байна. | ХХҮЕГ | ХАБЭМТ | 2017-2020 |
| 4.5.3. | Мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсч байгаа хүчин зүйл, шалтгааныг судлан дүгнэлт хийх, урьдчилан сэргийлэх арга замын талаар зөвлөмж боловсруулан гаргах. | Судалгаа-1<br>Зөвлөмж-1 | Судалгаа хийгдэж, урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр сайжирсан байна. | ХАБЭМТ, ХНХСИ | ХНХЯ | 2019 |
| **Зорилт 5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн судалгаа шинжилгээний ажлыг хөгжүүлэн, статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгоно.** | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 5.1** Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, статистик мэдээллийн системийг боловсронгуй болгох | | | | | | |
| 5.1.1 | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, статистик мэдээллийг боловсронгуй болгож, хэрэглэж хэвшүүлэх | Статистик | Статистик мэдээллийг боловсронгуй болгож, хэрэглэж хэвшсэн байна. | МХЕГ | ХНХЯ | 2017-2018 он |
| 5.1.2 | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, статистик мэдээллийн талаар ААНБ-ыг хамруулсан сургалт зохион байгуулах | Сургалт | Сургалт зохион байгуулагдсан байна. | МХЕГ | МАОЭНХ, МҮЭХ, ААНБ | 2017-2020 |
| 5.1.3 | МШӨ-ний судлан бүртгэх цахим мэдээллийн нэгдсэн сантай болох, статистик мэдээллийг олон нийтэд ил тод, хүртээмжтэй болгох | Мэдээллийн сан | Мэдээллийн нэгдсэн сантай болсон байна. | ХАБЭМТ | ХНХЯ, ЭМЯ | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 5.2** Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байрны хэмжилт, судалгааны нэгдсэн мэдээллийн сан бий болгох | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5.2.1 | Ажлын байранд ашиглахыг зөвшөөрсөн "Химийн хорт бодисын хор аюулыг лавлан мэдээлэх хуудас /MSDS/-ны цахим мэдээллийн сан"-г бий болгох | Мэдээллийн сан | Мэдээллийн сантай болсон байна. | ХАБЭМТ, НЭМҮТ | ЭМЯ, БОАЖЯ, ХНХЯ | 2017-2018 |
| 5.2.2 | Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудын ажлын байрны хэмжилт, судалгааны нэгдсэн мэдээллийн санг салбар тус бүрээр бий болгох | Мэдээллийн сан | Хэмжилт, судалгааны нэгдсэн мэдээллийн сантай болсон байна. | ХАБЭМТ, МХЕГ | Итгэмжлэгдсэн лабораториуд | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 5.3** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны судалгаа хийж, нэгдсэн мэдээллийн сан бий болгох | | | | | | |
| 5.3.1 | ХАБЭА-н ажилтны судалгаа хийх | Судалгаа | Судалгаа хийгдсэн байна. | ХНХЯ, АШУҮИС | ГОУХАН-ЭТИС | 2017 |
| 5.3.2 | ХАБЭА-н ажилтны мэдээллийн сантай болж, бодлого шийдвэрт ашиглах | Мэдээллийн сан | Мэдээллийн сантай болсон байна. | ХАБЭМТ | ХНХЯ | 2017-2018 |
| 5.3.3 | ХАБЭА-н ажилтны мэдээллийг цуглуулах, нэгтгэх, мэдээлэх систем бий болгох журам боловсруулах | Журам | Журам боловсруулагдаж, хэрэгжиж эхэлсэн байна. | ХАБЭМТ | ХНХЯ | 2017-2018 |
| **Үйл ажиллагааны чиглэл 5.4** ХАБЭА-н сургалтын байгууллага, багш, сургалтанд хамрагдсан ажилтны талаарх мэдээллийн үзүүлэлт, маягтыг боловсруулж, цахим хэлбэрээр мэдээлэл авах | | | | | | |
| 5.4.1 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын байгууллагуудаас мэдээ авах маягтыг боловсруулж мөрдөж хэвших | Маягт | Маягт боловсруулсан байна. | ХАБЭМТ | ХАБЭА-н сургалтын байгууллагууд | 2017 |
| 5.4.2 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын байгууллагуудаас мэдээг цахим хэлбэрээр тогтмол хугацаанд авч мэдээллийн сан бий болгох | Мэдээ | Мэдээллийн сантай болсон байна. | ХАБЭМТ | ХАБЭА-н сургалтын байгууллагууд | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 5.5** ҮОМШӨ зонхилон гарч байгаа шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга замын талаарх судалгааг тодорхой салбаруудыг сонгон хийх, бүртгэл мэдээллийг боловсронгуй болгох | | | | | | |
| 5.5.1 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний нөхцөл байдал, шалтгаан, урьдчилан сэргийлэх арга замын талаарх судалгааг тухайлсан салбаруудыг сонгон хийж, санал дүгнэлт, зөвлөмж боловсруулах | Судалгаа | Судалгаа хийгдэн зөвлөмж гарсан байна. | ХАБЭМТ | ХНХСИ | 2018 он |
| 5.5.2 | Мэргэжлээс шалтгаалсан өвчний мэдээллийг "Эрүүл мэндийн статистик бүртгэл"-д оруулж, шинэчлэх | Бүртгэл, мэдээлэл | Эрүүл мэндийн статистик мэдээлэл МШӨ-ний мэдээлэл орсон байна. | ЭМЯ, ХАБЭМТ | ХНХЯ | 2017-2018 |
| **Үйл ажиллагааны чиглэл 5.6** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн судалгаа, шинжилгээний ажлыг салбарын судалгааны институтыг түшиглэн хөгжүүлэх | | | | | | |
| 5.6.1 | Бичил уурхай эрхлэгчдийн дунд гарсан | Судалгаа-1 | Судалгаа хийгдсэн байна. | ХНХСИ, | ХНХЯ | 2017-2017 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үйлдвэрлэлийн ослыг бууруулах арга зам, хүчин зүйл | | | ХАБЭМТ | | |
| 5.6.2 | Малчдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад нөлөөлөх хүчин зүйл | Судалгаа-1 | Судалгаа хийгдсэн байна | ХНХСИ, ХАБЭМТ | ХНХЯ | 2017-2018 |
| 5.6.3 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллагчдын халдварт өвчинд өртөх өртөлт, МШӨ-ний судалгаа хийх | Судалгаа-1 | Судалгаа хийгдсэн байна. | ЭМЯ, ХАБЭМТ | ХНХЯ | 2018 он |
| **Зорилт 6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.** | | | | | | |
| **Үйл ажиллагааны чиглэл 6.1** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлж, чиглэл, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах | | | | | | |
| 6.1.1 | Салбарын яамдад ХАБЭА-н салбар хороог байгуулж, салбар хорооны дарга, нарийн бичгийн дарга нарын чадавхи бэхжүүлэх сургалтыг зохион байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах | Салбар хороо | Салбар хороодын үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Бүх яамд, ХАБЭА-н Үндэсний хороо | Салбар хороод | 2017-2020 |
| 6.1.2 | Салбарын яамдад ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан /бүтэц/ бий болгох | Орон тооны ажилтан | Орон тооны ажилтантай болсон байна. | Салбарын яамд | Яамдын салбар хороо | 2017-2020 |
| 6.1.3 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг сумдад байгуулж ажиллуулах арга хэмжээг зохион байгуулах | ХАБЭА-н зөвлөл | Сумдад зөвлөл байгуулагдсан байна. | Аймгийн Засаг дарга, ХАБЭА-н зөвлөл | ХАБЭА-н Үндэсний хороо | 2017-2020 |
| 6.1.4 | ХАБЭА-н Үндэсний хорооноос шинээр ажилд орсон болон залуу ажилтнуудад зориулсан гарын авлага, анхааруулга, зөвлөмжийг салбарын хороодтой хамтран боловсруулж гаргах | Гарын авлага материал 5 | Гарын авлага материал хэвлүүлсэн байна. | Салбарын яамд | ХАБЭА-н Үндэсний хороо, салбар хороо | 2018-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 6.2** ХАБЭА-н хяналтын чиглэл, арга хэлбэрийг шинэчилж, төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, өргөдөл гомдолд үндэслэсэн гэнэтийн хяналт шалгалтыг зөв зохистой хослуулах ажлыг зохион байгуулж, зөвлөн туслах үйл ажиллагааг өргөжүүлэх | | | | | | |
| 6.2.1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтран ажиллах төлөвлөгөөг жил бүр баталж, хөдөлмөрийн харилцаа, ХАБЭА-н чиглэлээр хамтарсан хяналтыг хэрэгжүүлэх | Төлөвлөгөө-3 | Төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | ХНХЯ, МХЕГ | Аймаг, нийслэл, дүүргийн МХХ, ХХҮГ | 2017-2020 |
| 6.2.2 | Хяналт шалгалтыг хийхдээ эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, зөвлөн туслах үр нөлөөтэй механизмыг бий болгож төлөвшүүлэхэд анхаарч ажиллах | Зөвлөн туслах үйлчилгээ | Зөвлөн туслах үйл ажиллагааны чанар, хүртээмж сайжирсан байна. | МХЕГ | Аймаг, нийслэл, дүүргийн МХХ | 2017-2020 |
| 6.2.3 | Аж ахуй нэгж байгууллагын дотоод хяналтыг сайжруулах болон ХАБЭА-н олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхэд ээд, үйлдвэрчний байгууллага, ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх | Хяналт | Олон нийтийн хяналтын үйл ажиллагаа эрчимжсэн байна. | ХАБЭМТ, МХЕГ | МАОЭНХ, МҮЭХ, ТББ, ААНБ бүр | 2017-2020 |
| 6.2.4 | Асбест хэрэглэдэг ажлын байруудад агаарын бохирдлын хяналт, мониторинг хийдэг тогтолцоог бий болгох | Хяналт | Ажлын байрны агаар асбестаар бохирдож байгаа эсэхэд хяналт | МХЕГ, НЭМХ | ХАБЭМТ | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | тавьдаг болно. | | | |
| 6.2.5 | ХАБЭА-н хяналтын чиглэлээр байцаагчдад зориулсан гарын авлага боловсруулж хэвлүүлэх | Гарын авлага- 1 | Гарын авлага боловсруулж хэвлүүлсэн байна. | ХНХЯ, МХЕГ | ОУХБ | 2018-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 6.3** Ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллага, ХАБЭА-н чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын оролцоо, үйл ажиллагаар дэмжих, хамтын ажиллагаар өргөжүүлэх | | | | | | |
| 6.3.1 | Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрт ХАБЭА-н асуудлыг тусган, хэрэгжилтийг зохион байгуулах | Хэлэлцээрт ХАБЭА-н асуудлыг оруулах | ХАБЭА-н асуудал хэлэлцээрт тусгагдсан байна. | ХНЗГТҮХороо<br>ХАБЭА-н үндэсний хороо | МҮЭ-ийн холбоо<br>МАОЭНХ | 2017-2020 |
| 6.3.2 | Уул уурхай, барилга зэрэг салбарт ХАБЭА-н бага хурал, зөвлөгөөн зохион байгуулах | Бага хурал, Зөвлөгөөн | Бага хурал, зөвлөгөөн зохион байгуулагдсан байна. | Салбарын яамд | Салбарын мэргэжлийн холбоод, ТББ | 2017-2020 |
| 6.3.3 | ХАБЭА-н сургалт, хуулийн хэрэгжилтийн үзлэг зохион байгуулах, судалгаа хийх, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх, бодлого, аргачлал, зөвлөмж боловсруулах зэрэг ажилд ТББ-ын оролцоог өргөжүүлэх | Сургалт, үзлэг, шалгалт, нөхцөлийн үнэлгээ | ТББ-ын оролцоо, хамтын ажиллагаа өргөжсөн байна. | ХНХЯ, ХАБЭА-н үндэсний хороо | МАОЭНХ, МҮЭХ, Мэргэжлийн холбоод, ТББ | 2017-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 6.4** ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээний орон нутаг, салбарын санхүүжилтийг аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын болон салбар хариуцсан Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусган хэрэгжүүлэх | | | | | | |
| 6.4.1 | Төр, төсвийн байгууллагуудын ХАБЭА-н зардлын хувь хэмжээг төсвийн зардлын ангилалд тусдаа үзүүлэлт болгон оруулж, асуудлыг шийдвэрлэх | ХАБЭА-н зардал | Төсвийн байгууллагын зардлын ангилалд тусгасан байна. | Сангийн яам | ХНХЯ | 2017-2018 он |
| 6.4.2 | ХАБЭА-н зөвлөлийн үйл ажиллагааны болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын төсвийн багцад тусган хэрэгжүүлж хэвших | ХАБЭА-н зардал | ХАБЭА-н зардлыг төсвийн багцад суулгах асуудлыг шийдвэрлэсэн байна. | Аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг дарга, ХАБЭА-н зөвлөл | Аймаг, нийслэл, дүүрэг сумын ИТХ | 2018-2020 он |
| 6.4.3 | ХАБЭА-н салбар хорооны үйл ажиллагааны болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусган хэрэгжүүлж хэвших | ХАБЭА-н зардал | ХАБЭА-н санхүүжилтийг Засгийн газрын гишүүний төсвийн багцад суулгах асуудлыг шийдвэрлэсэн байна. | Салбарын яамд | ХАБЭА-н салбар хороод | 2018-2020 он |
| **Үйл ажиллагааны чиглэл 6.5** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон нутгийн болон аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдыг чадавхижуулах арга хэмжээг авах | | | | | | |
| 6.5.1 | Аймаг, нийслэл, дүүргийн ХХҮГ-ын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Сургалт - 3 | Сургалт зохион байгуулагдсан байна. | ХНХЯ | ХХҮЕГ | 2017-2020 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6.5.2 | Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах | Сургалт - 3 | Сургалт зохион байгуулагдсан байна. | МХЕГ | ХНХЯ | 2018-2020 |
| **Үйл ажиллагааны чиглэл 6.6** ХАБЭА-н удирдлагын тогтолцооны стандартыг аж ахуйн нэгж, байгууллагуудад нэвтрүүлэх, арга зүйн зөвлөмж болгон хэрэглэх санал санаачлагыг дэмжих | | | | | | |
| 6.6.1 | ХАБЭА-н удирдлагын тогтолцооны стандартыг ААНБ-уудад хэрэглэх арга зүйн зөвлөмж боловсруулах | Зөвлөмж | Зөвлөмж боловсруулсан байна. | ХНХЯ, ХАБЭА-н Үндэсний хороо | МҮЭХ, МАОЭНХ | 2018 |
| 6.6.2 | ХАБЭА-н удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн ААНБ-уудын талаарх мэдээллийг бий болгох | Мэдээлэл | ХАБЭА-н удирдлагын тогтолцооны стандарт нэвтрүүлсэн ААНБ-уудын мэдээллийн сантай болсон байна. | СХЗГ, МАОЭНХ, МҮХАҮТ-ын ХАБЭА-н зөвлөл | ХНХЯ | 2017-2020 |
| 6.6.3 | ХАБЭА-н удирдлагын тогтолцооны стандартыг ААНБ-д нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг төрийн болон ТББ-уудад итгэмжлэл олгох асуудлыг тодорхой болгох | Судалгаа | Итгэмжлэл олгох асуудлыг судалсан байна. | СХЗГ | ХНХЯ | 2017-2020 |
| 6.6.4 | Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны ISO 45001 стандартыг орчуулан үндэсний стандарт болгох | Үндэсний стандарт | ISO 45001 стандартыг орчуулан үндэсний стандарт болгож батлуулсан байна. | МАОЭНХ | ХНХЯ, СХЗГ | 2018-2019 |

......oOo.....

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| БХБЯ | Барилга, хот байгуулалтын яам |
| БСШУСЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам |
| БОАЖЯ | Байгаль орчин,аялал жуулчлалын яам |
| УУХҮЯ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам |
| ХХААХҮЯ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| СЯ | Сангийн яам |
| ЭХЯ | Эрчим хүчний яам |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| АШУҮИС | Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль |
| АМГТГ | Ашигт малтмал газрын тосны газар |
| ГБХЗХГ | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МҮОНРТ | Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз |
| МҮЭХ | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| МАОЭНХ | Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо |
| МХЕГ | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| МСҮТ | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв |
| НЭМҮТ | Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв |
| НЭМС | Нийгмийн эрүүл мэндийн сургууль |
| СХЗГ | Стандарт, хэмжилзүйн газар |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ХАБЭМТ | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв |
| ХНХСИ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт |
| ШУТҮИС | Шинжлэх ухаан, технологийн үндэсний их сургууль |
| ЭМНДЕГ | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар |
| ХАБЭА | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй |
| ОУХБ | Олон улсын хөдөлмөрийн байгууллага |
| ГОУХАН | Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин |